



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: Erdenezulb@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 261628 Цахим хаяг: Erdenechimegda@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 04/335

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 197,776.4 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлын онцолсон хэсэг

Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын 954.7 км.кв талбайд агаарын болон газрын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг 2,999,553.4 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэн, анхдагч материалыг хүлээн авч Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хүлээн зөвшөөрч бүртгэх, үр дүнг үнэлэх, данснаас хасах талаарх зохицуулалт тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2023 онд 7 зорилгын хүрээнд 24 зорилт, 166 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжилтийг тайлагнасан байна.

Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор тус яамны бүтэц орон тооны хязгаарыг 78 байхаар тогтоосныг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор 89 байхаар шинэчилсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 480,607,956.87 | 3,718,069,764.32 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 25,599,691.85 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 25,599,691.85 |
| 31210 | Төгрөг | 0.00 | 25,599,691.85 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 25,599,691.85 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 42,820.31 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 42,820.31 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 31,814,640.00 | 116,308,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 19,500,000.00 | 116,308,000.00 |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 12,314,640.00 | 0.00 |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 12,314,640.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 448,793,316.87 | 3,576,119,252.16 |
| 35100 | Түүхий эд материал | 0.00 | 19,855,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 0.00 | 19,855,000.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 0.00 | 2,999,553,406.84 |
| 35400 | Хангамжийн материал | 448,793,316.87 | 556,710,845.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,110,490.00 | 37,729,190.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 433,043,299.00 | 490,366,599.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 943,227.87 | 523,254.32 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 27,395,502.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 987,463,710.26 | 679,205,330.07 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 987,463,710.26 | 679,205,330.07 |
| 39200 | Биет хөрөнгө | 310,266,268.44 | 312,843,831.63 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,175,000.03) | (26,075,000.07) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 515,608,677.00 | 670,714,680.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (342,499,662.41) | (488,911,552.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 407,689,486.70 | 416,458,533.27 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (305,791,732.82) | (334,157,933.99) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 0.00 | 114,583,445.37 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | (86,202,840.44) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 677,197,441.82 | 366,361,498.44 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (810,868,081.75) | (1,121,704,025.13) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,468,071,667.13 | 4,397,275,094.39 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 10.00 | 2,770,410.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10.00 | 2,770,410.00 |
| 41300 | Өглөг | 10.00 | 2,770,410.00 |
| 41360 | Бусад өглөг | 10.00 | 2,770,410.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 10.00 | 2,770,410.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,468,071,657.13 | 4,394,504,684.39 |
| | Засгийн газрын оруулсан капитал | | |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,468,071,657.13 | 4,394,504,684.39 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,163,954,403.75 | 4,090,387,431.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,353,268,738.79 | 1,163,954,403.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (189,314,335.04) | 2,926,433,027.26 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,468,071,667.13 | 4,397,275,094.39 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,198,238,700.00 | 8,861,522,617.83 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 273,000,000.00 | 115,689,908.83 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 273,000,000.00 | 115,689,908.83 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0 | 115,689,908.83 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 22,829,291.85 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0 | 92,860,616.98 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 273,000,000.00 | 0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,925,238,700.00 | 8,745,832,709.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,925,238,700.00 | 8,683,269,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,925,238,700.00 | 8,683,269,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 62,563,709.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 62,563,709.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 5,211,322,479.42 | 5,921,829,773.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,211,322,479.42 | 5,921,829,773.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,720,917,309.94 | 5,403,558,714.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,130,814,164.14 | 2,938,070,068.44 |
| 210101 | Үндсэн цалин | 1,278,969,550.98 | 1,676,096,069.21 |
| 210102 | Нэмэгдэл | 454,014,981.40 | 572,684,970.05 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 245,993,376.00 | 321,023,000.00 |
| 210104 | Урамшуулал | 151,836,255.76 | 368,266,029.18 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 293,456,349.64 | 370,237,476.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 137,688,024.90 | 253,810,038.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,338,010.24 | 29,860,004.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,574,134.38 | 23,480,494.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 41,842,175.22 | 5,735,176.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 73,014,004.90 | 57,351,762.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 199,574,777.39 | 130,561,980.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,760,312.00 | 60,185,766.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,216,772.13 | 12,619,973.55 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 34,745,394.26 | 33,341,549.03 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 101,852,299.00 | 24,414,692.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 187,841,520.00 | 376,917,991.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 11,700,000.00 | 0 |
| 210604 | Урсгал засвар | 176,141,520.00 | 376,917,991.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 146,653,238.80 | 228,669,207.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 146,653,238.80 | 228,669,207.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,205,328,861.86 | 747,297,012.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,135,820,019.86 | 738,549,658.28 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 685,392.00 | 158,934.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 67,331,530.00 | 7,140,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 557,248,398.11 | 611,804,979.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,700,928.82 | 146,251,098.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,539,000.00 | 9,640,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 435,008,469.29 | 455,913,880.50 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 490,405,169.48 | 518,271,059.03 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 270,194,843.41 | 341,498,304.25 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 23,355,000.00 | 22,892,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 148,800,000.00 | 200,950,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 88,224,925.00 | 51,456,270.25 |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,814,918.41 | 66,199,434.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 220,210,326.07 | 176,772,754.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 220,210,326.07 | 176,772,754.78 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (13,083,779.42) | 2,939,692,843.93 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 176,230,555.62 | 13,259,816.67 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 176,230,555.62 | 13,259,816.67 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (189,314,335.04) | 2,926,433,027.26 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------------|---|
| 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 304,117,253.38 | | 1,353,268,738.79 | 1,657,385,992.17 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 304,117,253.38 | | 1,353,268,738.79 | 1,657,385,992.17 |
| Тайлант үеийн үр дүн | | | -189,314,335.04 | -189,314,335.04 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 304,117,253.38 | | 1,163,954,403.75 | 1,468,071,657.13 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 304,117,253.38 | | 1,163,954,403.75 | 1,468,071,657.13 |
| Тайлант үеийн үр дүн | | | 2,926,433,027.26 | 2,926,433,027.26 |
| 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл | 304,117,253.38 | | 4,090,387,431.01 | 4,394,504,684.39 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 4,925,238,700.00 | 8,771,432,400.85 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 25,599,691.85 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 25,599,691.85 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 22,829,291.85 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 22,829,291.85 |
| 120009 | Бусад орлого | | 2,770,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,925,238,700.00 | 8,745,832,709.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 4,925,238,700.00 | 8,683,269,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,925,238,700.00 | 8,683,269,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 62,563,709.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 62,563,709.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,925,238,700.00 | 8,745,832,709.00 |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,925,238,700.00 | 8,745,832,709.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,415,333,530.52 | 8,163,861,649.97 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,130,255,558.14 | 2,938,118,385.39 |
| 210101 | Үндсэн цалин | 1,278,410,944.98 | 1,676,289,013.61 |
| 210102 | Нэмэгдэл | 454,014,981.40 | 572,684,970.05 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 245,993,376.00 | 320,878,372.55 |
| 210104 | Урамшуулал | 151,836,255.76 | 368,266,029.18 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 294,014,955.70 | 370,231,976.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 200,742,686.54 | 253,804,539.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,996,517.98 | 29,860,004.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,574,134.38 | 23,480,494.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,609,565.20 | 5,735,176.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,092,051.60 | 57,351,762.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 79,411,749.26 | 81,155,706.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,745,700.00 | 24,367,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,160,000.00 | 12,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 34,745,394.26 | 30,366,752.78 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,760,655.00 | 14,221,354.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 223,664,340.00 | 442,984,031.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 33,449,320.00 | 53,458,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,513,500.00 | 12,607,340.00 |
| 210604 | Урсгал засвар | 173,701,520.00 | 376,917,991.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 158,967,878.80 | 216,354,567.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 158,967,878.80 | 216,354,567.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,381,822,361.80 | 3,917,420,318.09 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,312,313,519.80 | 3,833,869,167.84 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 685,392.00 | 158,934.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 67,331,530.00 | 81,944,296.25 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 147,196,686.82 | 197,596,664.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 137,657,686.82 | 185,687,204.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,539,000.00 | 11,909,460.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 509,905,169.48 | 581,971,059.03 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 289,694,843.41 | 405,198,304.25 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 23,355,000.00 | 22,892,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 168,300,000.00 | 227,650,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 88,224,925.00 | 51,456,270.25 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,814,918.41 | 103,199,434.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 220,210,326.07 | 176,772,754.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 220,210,326.07 | 176,772,754.78 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 0 | 25,599,691.85 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0 | 25,599,691.85 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 25,599,691.85 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|-------------------------|-------------------------|-------------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,683,269,000.00 | 8,506,933,854.22 | (176,335,145.78) | 98.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,683,269,000.00 | 8,506,933,854.22 | (176,335,145.78) | 98.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,313,194,700.00 | 8,138,735,549.97 | (174,459,150.03) | 97.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,080,777,900.00 | 2,938,118,385.39 | (142,659,514.61) | 95.4 |
| 210101 | Үндсэн цалин | 1,612,227,200.00 | 1,676,289,013.61 | 64,061,813.61 | 104.0 |
| 210102 | Нэмэгдэл | 914,394,900.00 | 572,684,970.05 | (341,709,929.95) | 62.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 316,710,000.00 | 320,878,372.55 | 4,168,372.55 | 101.3 |
| 210104 | Урамшуулал | 237,445,800.00 | 368,266,029.18 | 130,820,229.18 | 155.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 385,096,700.00 | 370,231,976.91 | (14,864,723.09) | 96.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 258,665,900.00 | 253,804,539.39 | (4,861,360.61) | 98.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,607,600.00 | 29,860,004.63 | (1,747,595.37) | 94.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,286,200.00 | 23,480,494.28 | (1,805,705.72) | 92.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,321,400.00 | 5,735,176.32 | (586,223.68) | 90.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 63,215,600.00 | 57,351,762.29 | (5,863,837.71) | 90.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,051,600.00 | 81,155,706.78 | (3,895,893.22) | 95.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,500,100.00 | 24,367,600.00 | (132,500.00) | 99.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,311,100.00 | 12,200,000.00 | (1,111,100.00) | 91.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 32,989,100.00 | 30,366,752.78 | (2,622,347.22) | 92.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,251,300.00 | 14,221,354.00 | (29,946.00) | 99.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 424,897,300.00 | 423,357,931.00 | (1,539,369.00) | 99.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 34,336,700.00 | 33,832,600.00 | (504,100.00) | 98.5 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 12,614,400.00 | 12,607,340.00 | (7,060.00) | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 377,946,200.00 | 376,917,991.00 | (1,028,209.00) | 99.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 216,360,800.00 | 216,354,567.00 | (6,233.00) | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 216,360,800.00 | 216,354,567.00 | (6,233.00) | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,951,571,500.00 | 3,917,420,318.09 | (34,151,181.91) | 99.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,867,225,900.00 | 3,833,869,167.84 | (33,356,732.16) | 99.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,960,400.00 | 1,447,920.00 | (512,480.00) | 73.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 236,700.00 | 158,934.00 | (77,766.00) | 67.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 82,062,700.00 | 81,944,296.25 | (118,403.75) | 99.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,170,000.00 | 192,096,664.80 | (4,073,335.20) | 97.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,501,900.00 | 180,187,204.80 | (314,695.20) | 99.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,668,100.00 | 11,909,460.00 | (3,758,640.00) | 76.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 343,343,200.00 | 368,198,304.25 | 24,855,104.25 | 107.2 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 22,892,600.00 | 22,892,600.00 | 0.00 | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 202,085,500.00 | 227,650,000.00 | 25,564,500.00 | 112.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,707,800.00 | 51,456,270.25 | (251,529.75) | 99.5 |

| | | | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|-------------------------|-------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 66,657,300.00 | 66,199,434.00 | (457,866.00) | 99.3 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 8,683,269,000.00 | 8,506,933,854.22 | (176,335,145.78) | 98.0 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 8,683,269,000.00 | 8,506,933,854.22 | (176,335,145.78) | 98.0 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 8,683,269,000.00 | 8,506,933,854.22 | (176,335,145.78) | 98.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 89 | 89 | | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 19 | 19 | | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 67 | 67 | | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | | 100 |

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------|--|------------|----------------------|
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 62,563,709.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 62,563,709.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 25,126,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 19,626,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 19,626,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,500,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 37,437,609.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 37,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 37,000,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 437,609.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 437,609.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 62,563,709.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 62,563,709.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 62,563,709.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 107,933.0 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 107,933.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, залруулаагүй алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Үүнээс дараах алдааг залруулсан. Үүнд:

- Тайлант онд 50,808.0 мянган төгрөгийн лицензийн төлбөрийг урьдчилж гарсан зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн,
- Эрдэм судалгаа, шинжилгээний 57,125.0 мянган төгрөгийн 2 ажлын тайланг бараа материалын тайланд орлого аваагүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Аудитаар нийт 197,776.4 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 34,717.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 163,058.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 197,776.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|----------|------------------|----------|-----------------|----------|------------------|--|--|--|--|--|--|
| Геофизикийн судалгааны цогцолбор ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэхээр ажилласан 7,611.8 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг техник, хяналтын ажлын зардлаас бус урсгал зардлаас гаргасан. | 1 | 7,611.8 | 1 | 7,611.8 | | | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл дутуу 23,489.4 мянган төгрөгийн, албан томилолтын журмыг мөрдөөгүй 8,109.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан. | 1 | 31,598.6 | | | 1 | 31,598.6 | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн горимыг зөрчиж салбарын 100 жилийн ойн арга хэмжээнд 8,260.0 мянган төгрөг зарцуулсан. | 1 | 8,260.0 | | | 1 | 8,260.0 | | | | | | |
| Салбарын үйл ажиллагааны чиглэлээр мэдээ мэдээлэл, сурталчилгаа хийлгэхээр 15 хуулийн этгээдтэй 95,600.0 мянган төгрөгийн, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар 27,600.0 мянган төгрөгийн үйлчилгээ авахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөөгүй, шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс хэвлэл, мэдээллийн ажлуудаас 14,600.0 мянган төгрөгийн 3 гэрээний гүйцэтгэлийн тайлангүй, гэрээнүүдэд хавсралт 2-т заасан ажлыг хийхээр заасан ч хийх ажлын нэр төрөл, үнэ өртгийг тодорхой тусгаагүй, 14,000.0 сая төгрөгийн ажлын даалгавар, төсөв, хийсэн ажил нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд байна. | 1 | 123,200.0 | | | 1 | 123,200.0 | | | | | | |
| УУХҮЯ-ны нягтлан бодогчийн ажил үүргийг Төрийн сангийн шинжээчээр давхар гүйцэтгүүлж байгаа нь тус яамны төсвийн зарцуулалт, ажил гүйлгээнд тавих хяналт алдагдаж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаан дахь дотоод хяналт сулрах эрсдэл үүссэн байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Жилийн эцсийн тооллогын бүртгэлийг бодитой, чанартай хийж гүйцэтгээгүй, тооллогын бүртгэлийг нэгтгэж холбогдох акт үйлдээгүй байна. Ажлын хэсэг зөвхөн ажилтнуудын хариуцсан хөрөнгийг тоолж картад гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд агуулахад байгаа болон нярвын хариуцсан хөрөнгийг тоолсон тооллогын бүртгэл байхгүй, комиссын илтгэх хуудсаас харахад 114,582.5 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 300,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг тооллогод хамруулаагүй, бараа материалын дүн зөрүүтэй тоолсон гэж тэмдэглэгдсэн байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Нийт дүн | 7 | 197,776.4 | 2 | 34,717.8 | 5 | 163,058.6 | | | | | | |